

Шашны олон ургальч үзэл ба Монголын онцлог

Удо Б. Баркманн

Монголд төрийн социализм нуран унасны дараа Христосын шашны янз бүрийн урсгал чиглэл, чөлөөт шашныхан (Еховын гэрч нар, баптистууд, адвентистүүд, пресбытерианууд, мормонууд, Шинэ апостолийн сүмийнхэн) өөр өөрсдийн сургаалийг номлох үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш шашны олон ургальч үзэл ба үндэсний аюулгүй байдлын хоорондын уялдаа холбоо тус орны улс төрд оролцогч олон нийтийн дунд байн байн нухацтай яригддаг сэдэв болсоор ирэв. Энэ нь ч Монголд өрнөж буй улс төрийн шилжилтийн үйл явцтай холбоотой нэгэн онцлог асуудлын илрэл гэдгийг төвөггүйхэн ойлгож болно.

Шарын шашин - монголчуудын уламжлалт шашин

Олон зууны тэртээгээс Бурхны шашны Төвдийн хувилбар болох Шарын шашин (ламаизм) монголчуудын шашны хийгээд оюуны амьдралд давамгайлж иржээ.¹ Монголд Христосын шашныг номлох гэсэн оролдлого жишээлбэл 19-р зуун, 20-р зууны эхээр байн байн гарч байсан боловч ер үр дүнд хүрч байсангүй.² Үүний шалтгаан нь Шарын шашин Монголын ард түмний амьдралд гүнзгий нэвтэрсэн, Гадаад Монгол Манж-Хятадын Чин улсын бүрэлдэхүүнд "гадаад муж" гэх онцгой статустай байсан хийгээд түүнээсээ болж ертөнцөөс таслагдсан, мөн Хятад, Орос хоёрт тэдгээр улсын дүр төрхийг 20-р зууны турш илэрхийлсэн нийгмийн хувьсал өөрчлөлтүүд явагдсанаас үүдэлтэй юм. Үүнд:

1. Шарын шашин нь Халх Монгол, хожмын Гадаад Монгол буюу Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дэвсгэр дээр 16-зууны хоёрдугаар хагасаас эхлэн төрийн шашин төдийгүй бөө мөргөлийн элементүүдтэй нийлэгжин ардын шашин болтлоо бэхжсэн. Шарын шашинжуулах үйл ажиллагааны хүрээнд сүм хийдийн нягт сүлжээ үүссэн бөгөөд Зөвлөлтийн ДХАК (Дотоодыг Хамгаалах Ардын Газар)-аас 1937 оны орчимд хийсэн нэгэн судалгаагаар түүнд 800-аад сүм

1 Barkmann, U. B. "Lamaismus in der Mongolei". *Asien, Afrika, Lateinamerika* 22(1994). 45-56-р талуудад үзнэ үү.

2 Hawden, C. R. "Shamans, Lamas and Evangelicals". *The English Missionaries in Siberia*. London 1985.

хийд хамрагдаж байжээ. Шарын шашны хийдүүд нь бас монголчуудын оюуны амьдралын цорын ганц төв байв. Нийт хүн ам нь 542.000-хан хүнтэй байсан Гадаад Монгол 1918 оны орчимд 115.000 ламтай байлаа. Тэгэхээр монгол айл болгоноос наад зах нь нэг эр хүн хүн лам байсан аж. Тийм болохоор амьдралын бүхий л салбарт шашны нөлөө маш өндөр түвшинд нэвтэрсэн байжээ.

2. Манж улсын хаад (1644-1911) Шарын шашныг хөхүүлэн дэмждэг байв. Тэд уг шашин хийгээд түүний толгойлогчид – Төвдийн Далай лам, Халх Монголын Жавзандамба нарыг монголчуудыг өөрийн эзэнт улсын бүрэлдэхүүнд бат бэх оруулахад чиглэсэн бодлогынхоо чухал хэрэглүүр хэмээн үздэг байв. Христосын шашныг номлох гэсэн оролдлогууд үндсэндээ Орос улсаас л гарч байсан тул Чин улсын албад түүнийг нь өрсөлдөгч умрын гүрэн цэрэг-стратегийн санаархлаар монголчуудын дунд нөлөөгөө бэхжүүлэх гэсэн оролдлого хэмээн дүгнэж эсэргүүцэн тэмцдэг байлаа.
3. Хятадын хувьсгалын дүнд (1911 он) монголчууд Оросын тусламжтайгаар Хятадаас салаад, Гадаад Монголд үндэсний төр улсаа байгуулж эхлэв. Монголчуудын тусгаар тогтнох эрмэлзлийн биет төлөөлөл нь Гадаад Монголын Шарын шашны тэргүүн Жавзандамба өөрөө байсан явдал Шарын шашны байр суурь, нэр хүндийг ард түмний дотор ихээхэн бэхжүүлжээ. Хэдий тийм боловч тухайн үед Шарын шашинд шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай нь улам бүр харагдсаар атал түүнийгээ хэрэгжүүлэх дотоод нөөц хүч өөрт нь байхгүй болчихоод байсныг анзаарахгүй өнгөрч болохгүй.

Төрийн социализмын үед Шарын шашныг шахан зайлуулсан нь

Социалист хөгжлийн жилүүдэд ЗХУ-аас ирсэн зөвлөхүүд болон Москваг дуулгавартай аялдан дагагч Монголын нам, төрийн удирдлага Шарын шашны эсрэг жинхэнэ аян дайн явуулсан юм. Шашны эсрэг бодлого бүр 20-иод онд Засгийн газраас гаргасан хэд хэдэн тогтоол шийдвэрийг хэрэгжүүлснээр эхэлсэн ажээ. Шарын шашны нэр цуутнууд үндсэндээ шашны томчуудын хойд

дүр байдаг тул Улсын Их Хурлаас 1929 оны 2-р сарын 15-ны өдөр Жавзандамба болон бусад хутагт, хувилгаадын¹ хойд дүрийг тодруулахыг хориглох тухай шийдвэр гаргаж, түүнээ хэрэгжүүлсэн нь лам хуврага нарыг толгойлох хүнгүй болгоход чиглэсэн том цохилт байлаа.²

1937 оны орчим Монголын Засгийн газар Москвагийн тушаалаар бараг бүх хийдүүдийг эвдэн нурааж, мянга мянган лам нарыг бие махбодийн хувьд егүүтгэжээ. Тэгсээр 1940 оны Үндсэн хуулиар төр, шашин хоёрыг тусгаарлахаар болсны зэрэгцээ түүндээ “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэн нь шашин шүтэх ба шашны эсрэг суртал нэвтрүүлэх бүрэн эрхтэй болно.” хэмээсэн увайгүйхэн заалт оруулсан байдаг юм.³

Төр иргэдийнхээ шашны аливаа үйл ажиллагааг эсэргүүцэн тэмцсэн учир Шарын шашин яваа яваандаа зөвхөн гэр бүлийн ивцүү хүрээнд л шүтэгдэх болов. Эрдэмтэй лам нар нь 30-аад оны хэлмэгдүүлэлтэд өртөөд байсан болохоор шашин шүтлэгийн асуудлаар олигтойхон зөвлөчих хүн ч алга байлаа. Тэдний залгамж халаа гэж байсангүй. Үүний уршгаар Шарын шашинтнууд хэдхэн үеийн дотор Бурхан багшийн сургаалийн гол санааны нарийн ширийн зүйлсийг огт мэдэхгүй тийшээ хандах болжээ. Тэгэхдээ “хувьсгалын” өмнөх (1921 оноос өмнөх) үеийн сүсэгтнүүд шашны талаарх тодорхой мэдлэгийн хувьд тун маруухан байсныг мартаж болохгүй. Тэр үед хүн ам бараг бүхэлдээ бичиг үсэггүй байлаа. Тийм болохоор Бурхны шашны сургаалийн талаар тодорхой мэдэх зүйл нь туйлын доод түвшинд байсан гэхэд болно. Иймд энэ үеийн шашинд гүнзгий автсан байдал нь ард түмний мухраар сүсэглэн бишрэх мэдрэхүйтэй таарч байсан бөгөөд Шарын шашны лам нар түүнийг нь оюуны өндөр шаардлагатай тулгаралгүй элдэв зан үйлдээ ашигладаг байжээ. Үүнтэй холбоотойгоор, уйгуржин-монгол цагаан толгойг кирилл үсгээр орлуулах зорилгоор 1941 онд Зөвлөлтийнхний санаачлан хэрэгжүүлсэн “бичгийн шинэчлэл”-ийн үр дагаврыг төдийлөн хайхарсангүй. Засгийн газар сургуульд заавал сургах журмыг дөнгөж 40-өөд оны эхнээс мөрдсөн тул

1 Хутагт = Далай лам буюу Баичин Эрдэнэ нараар болгоолдох учиртай өндөр зиндааны (товдоор Ринбүүч, санскритгаар Махарадна буюу “Их Эрдэнэ”) хойд дүр.

Хувилгаан = Монголд ихэвчлэн том санваартны хойд дүр (товдоор Прүлскү, санскритаар Нирманакая) байдаг. Зиндаагаараа хутагтын дараа орно.

2 Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн Хууль, түүнд холбогдох зарим актын өмхтгэл, Улаанбаатар 1972, 220-р гал.

3 Мон гүнд, 323-р тал.

залуу үеийнхэн анхнаасаа л кирилл бичгээр явдаг болсон байна. Өмнө нь бичиг үсэггүй байсан ахмад үеийнхэн одоо шинэ бичиг заалгажээ. Тэгвэл Бурхны шашны ном бүтээлүүд анх хэрэв төвд хэлээр гараагүй л бол монгол хэлээр бичигдсэн байсан юм. Тэгэхээр залуу үеийнхэн эдгээрийг уншиж чадахгүй болжээ. Үүний уршиг гэвэл, монголчуудын оюуны амьдралыг хуучин монгол, мөн Бурхны шашны бичиг соёлоос нь салгасан явдал юм. Ингээд хожуу үеийнхэн нь хуучин бичгээ сурах гэж хичээхээ больсон билээ.

1944 оноос эхлэн Улаанбаатар дахь Гандантэгчинлэн хийдэд хурал номоо хуруулахыг зөвшөөрснөөр тэр нь ийм эрх бүхий Монголын цорын ганц хийд болов.

Гэвч оюуны амьдалын нэг төв болж хөгжих нөхцөл нь 1990 оныг хүртэл туйлын хязгаарлагдмал байсан нь социалист төрөөс түүнийг улс төрийн хэрэглүүр болгож байсантай холбоотой юм. Төр "шашны үйл ажиллагааг чөлөөтэй болгосноо" энэхүү хийдийн тусламжтайгаар Барууны орныхонд харуулахыг зорьж байлаа. Гэтэл тус хийдийн Хамба лам нар бүгдээрээ дангаар эх баригч Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын гишүүн байсан, энэ намын Төв Хороо буюу Улс Төрийн Товчооны шийдвэрээр уг зиндаанд тавигдсан хүмүүс байжээ. Х. Гаадан тус хийдийн Хамба ламаар "томилогдсон" тухайгаа бичихдээ, "Би 1981-1990 оны дунд хүртэл Гандантэгчинлэн хийдийн хамба лам байв. Хамба нь Азийн буддистуудын энх тайвны бага хурлын ерөнхийлөгч болох тул шашны хуучин номтой, орчин үеийн боловсролтой хүн хэрэгтэй байжээ. НТХ-ны нарийн бичгийн дарга Т. Адъяа намайг дуудаад "Азийн буддистуудын хуралд явах шашин номын мэдлэгтэй, орчин үеийн боловсролтой хүн хэрэгтэй байна. Ганданд лам бол, намын батлахаа хураалгачих" гэсэн... УТТ-оор батлахад би биеэр оролцоогүй."¹ гэсэн байдаг.

1990 онд монголчуудын хийсэн улс төрийн өөрчлөлт шинэчлэлээр л Шарын шашин дахин сэргэж чадсан билээ. Энэ нь үндэсний үзлийн түрлэг дунд явагдсан бөгөөд социализмын үеэс уламжлан үлдсэн өв тааруухан тул боломжийн хувьд анхнаасаа л хязгаарлагдмал байв. Учир нь:

1. Шарын шашны лам хуврагууд гэж жинхэнэ утгаараа байхгүй

¹ Гаадан, Х., "Янжиглхам бурхныг 720 аргаар зүйрлэн магтсан байдаг". Үнэн, Улаанбаатар, 1997.11.22-25.

болсон. Монголд улс төрийн шинэчлэл хийгдээд найман жил болчихоод байхад өдгөө ямар нэг хутагт хувилгааны хойд дүрээр тодорсон монгол лам байхгүй байна. Шашны суурь боловсрол гэвэл Шашны Дээд Сургууль төгссөн хэдхэн хүнд л байдаг.

2. Өнөөгийн хийдүүдэд материалаг бааз суурь байдаггүй. Хийдүүдийн дийлэнх олонхийг 30-аад онуудад эвдэн сүйтгэж, хөрөнгийг нь хуулиар хураажээ.
3. МАХН-аас олон үеийн турш хичээнгүйлэн явуулсан шашны эсрэг бодлого нийгмийг эхэн үедээ хүчээр шашингүйжүүлж, улмаар түүнийгээ байх ёстой ердийн зүйл болгосон. 80-аад онд МАХН-ын удирдлагын даалгавраар хийгдсэн социологийн дотоод судалгаануудаас үзэхэд амьдрал дээр байгаа Шарын шашинтнуудын тоо нийт хүн амын ердөө арваас арван найман хувийг л эзэлж байжээ.
4. Сүсэгтнүүдийн шашны боловсрол туйлын ядмаг байсан, одоо ч тийм байна.
5. Социализмын үеийн Шарын шашинд боловсролын хувьсгал хийгээд мэдлэгийн тэсрэлтийн үр дүнд бий болсон орчин цагийн оюуны шаардлагад нийцэж явах боломж байгаагүй.
6. Аль ч талаас нь харсан үнэт зүйлс болон ёс суртахууны тухай ойлголтуудын нэгдмэл тогтолцоо мэтээр монголчуудыг хэдэн арван жилийн турш итгүүлсээр ирсэн социализм нуран унахдаа хүмүүст томоохон хоосон орон зай үлдээсэн боловч Шарын шашин нь дээр дурдсан шалтгаануудын улмаас үнэт зүйлс болон ёс суртахууны ойлголтуудын тухайд өөрийн гэсэн альтернатив тогтолцоог байж болох нэг хувилбар болгон дэвшүүлж чадаагүй байна.

Шашны эрх чөлөө ба шашны олон ургальч үзэл

1990 оны улс төрийн өөрчлөлт шинэчлэлээр эхэлсэн нийгмийг ардчилах үйл явц монголчуудад шашны эрх чөлөөг нь эргүүлэн авчрав.

1991 оны 3-р сарын 26-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Шашны

асуудал эрхлэх зөвлөл байгуулах тухай Зарлиг гаргаж, түүнийхээ үүргийг дотоод дүрмэнд нь дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: “1. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх шашны асуудал эрхлэх зөвлөл нь төр, шашны харилцааг зохицуулах, шашин, сүм хийдийн талаархи төрийн бодлого, шийдвэрт эрдэмтэн, сэхээтэн, санваартан болох сүсэгтэн олны санал бодлыг тусгаж байх зорилго бүхий орон тооны бус зөвлөлдөх байгууллага мөн.”¹ гэжээ. Энэхүү зөвлөлийн бүрэлдэхүүнд Бурхны болон Лалын шашны санваартнуудын зэрэгцээ эрдэмтэд ч мөн оролцсон аж.

1994 онд дээрх байгууллагын бие бүрэлдэхүүнийг “хар болгож”, тэндээс шашны төлөөлөгчдийг нь гаргажээ. Зөвлөлийн үүргийг шинэ статуст тогтоохдоо, “Монгол улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх шашны асуудал эрхэлсэн зөвлөл нь төр, сүм хийдийн болон шашны хоорондын харилцааны талаар Монгол улсын хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Монгол Улсын Ерөнхийлөгчид мэргэжлийн үүднээс зөвлөн туслах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлдөх байгууллага мөн.”² гэсэн байв. Одоо бол зөвхөн төрийн өндөр албан тушаалтнууд, эрдэмтдээс бүрдээд буй уг зөвлөлд шашны олон ургальч үзлийн талаар эрчимтэй маргах болжээ. Тэнд орсон эрдэмтдийн зарим нь хувийн сонирхолдоо хөтлөгдөн язгуурын уламжлалт шашнууд буюу монголчуудын Шарын шашин, баруун Монголын казахуудын Лалын шашны зэрэгцээ мөн шинэ шашнуудын төлөөллийг ч бий болгох нь нийгмийн ардчиллын чухал үе болох шашны олон ургальч үзлийг хүндэтгэн үзэхэд зайлшгүй чухал гэсэн бодолтой байв. Тэдний энэ байр суурь нь Засгийн газрыг, хэдийгээр “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль”-ийн 4-р зүйлийн 7-р бүлэгт “... шашныг гаднаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.”³ гэж заасан ч гэлээ Христийн номлолыг дэлгэрүүлэх оролдлогод хүлээцтэй, уян хатан хандахад хүргэлээ. Нөгөө талаар энэ нь ихэнх улсуудад “шашны олон ургальч үзэл”-ийн зарчмыг юуны өмнө эдгээр орнуудад уламжлал болон тогтсон шашны бүлэглэлүүдийн хоорондын харилцааг зохицуулахад хэрэглэдэг гэдгийг орхигдуулсан юм.

1992 оны 2-р сарын 12-нд баталсан Монгол Улсын шинэ Үндсэн

1 Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг, Шашны асуудал эрхлэх зөвлөл байгуулах тухай, Төрийн мэдээлэл, Улаанбаатар, 3(1991), 236-239-р тал.

2 Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн дүрэм, Төрийн мэдээлэл, Улаанбаатар, 6(1994), 474-р тал.

3 Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, Улаанбаатар, 1993.

хуульд шашны эрх чөлөөг хүний болоод иргэний эрхийн хэмжээнд тунхаглажээ. Түүнд "1. Монгол улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ. 2. Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй. 3. Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна... 2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна... Монгол улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: ... 15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй"¹ гэж заасан байна.

Христийн номлолыг дэлгэрүүлэх оролдлогууд

Нэг талаар нийгэм ардчилагдсан, нөгөө талаар уламжлалт шашин сул дорой байсан явдал Христос шашны номлогч нарт Монголд үйл ажиллагаа явуулах орчныг нь бүрдүүлж өгчээ.

1990 оноос эхлэн АНУ, Их Британи, Герман, Өмнөд Солонгос, Японоос Христос шашны янз бүрийн, тэгэхдээ ихэвчлэн протестант чиглэлийн урсгал, сүм хийдийн төлөөлөгчид Улаанбаатарт ирж, монголчуудыг Христос шашинд оруулахыг эрмэлзэх болов. Мөн 90 оныхоо 10-р сарын 7-нд Улаанбаатар хотноо Библийн төв нээгджээ. Үүний дараахнаас энэ төвийнхөн нийслэл болон Дархан, Эрдэнэт хот, хэд хэдэн аймгийн төвд Христийн шашны арван ч сүмийг байгуулсан байна.

Христжүүлэх оролдлогод урьд өмнө нь ямар ч шашинд харьяалагдаж байгаагүй залуус, эмэгтэйчүүд ихээхэн дэмжлэг үзүүлэв. Эдгээр "шинэ христүүд"-ийн нэг онцлог нь Монголын соёлын хүрээнээс ангид шашныг хүлээн авахад бэлэн байсанд оршино. Харин тус орны Бурхны шашны нэр цуутай зүтгэлтнүүдийг нилээд хачирхалтай аргуудаар өөрсдийн шашинд оруулах буюу урвуулах гэсэн Христийн шашны зарим сүм хийдийн оролдлого талаар болсон билээ.

Христийн шашны бүлгүүдийн Монгол талын сурталчлагч нар онцгой сонирхол татдаг. Тэд гол төлөв гадаадын валютаар санхүүгийн дэмжлэг авдаг нь хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Улаанбаатар, 1992, 5, 7, 9-р тал.

байдалтай харьцуулбал том хэмжээний урамшуулал мөн. Гэхдээ Монголд соёлын хувьд нутагшаагүй шашны сүлжээ хэрвээ түүний идэвхтнүүд санхүүгийн ийм дэмжлэг авахаа больчих юм бол ямар хурдан нуран унах нь ч бас төсөөлөгддөг юм.

Стратеги Судлалын Хүрээлэнгээс хийсэн нэгэн судалгаагаар дээр дурьдсан Христийн шашны бүлгүүд 1991-1992 оны хооронд 4.000-5.000 орчим дагалдагчтай байсан бол тэдний тоо 1992-1993 оны хооронд бүр 6.000-7.000 болтлоо өссөн ажээ. 1993 онд явуулсан санал асуулгууд тэдгээрт оролцогсдын 9,7 хувь нь Христэд итгэгчид байсныг харуулдаг. Харин Шарын шашны хүрээнийхний тооцоолж буйгаар 1997 онд Хрисийн шашныг идэвхтэй дэмжигч 30.000-50.000 хүн байна гэсэн нь төдийлөн үнэмшилтэй биш санагдана.

“Төр, шашны хоорондын харилцааны тухай хууль”-нд зохих заалтууд орсон ч Монгол Улсын Засгийн газар Христийн номлогч нарт хүлээцтэй ханддагаа өөрчлөлгүй явсаар иржээ.

Христийн номлогчид ийнхүү амжилт олж байсныг юугаар тайлбарлах вэ? Монгол талын судалгаагаар Христос шашин багагүй дэмжлэг олоход дараах хүчин зүйлс нөлөөлсөн аж. Үүнд:

1. Христийн шашны үндсэн зарчим нийтэд ойлгомжтой, мөн Библи судрын орчуулга орос, монгол хэлээр гарсан байдаг нь ихээхэн үүрэг гүйцтгэсэн.
 2. Англи хэлтэй орнуудын шашин номлогч нар ихэвчлэн англи хэлний багшаар Монголд ирж, шашин номлох санаархлаа хэрэгжүүлэх зорилгоор хүн амын өргөн хүрээнд нэвтрэхдээ хэлний хичээлийг ашигласан.
 3. Христос шашин юуны өмнө залуусын хувьд өнөөг хүртэл олж мэдээгүй явсан танин мэдэхүйн шинэлэг ертөнц болж байсан учир тэд эхэн үедээ уг шашныг ихээхэн сонирхож, түүнд нээлттэй хандсан.
 4. Ахмад үеийнхний саяхан болтол баримталж асан үнэт зүйлс дампууралд орсон явдал залуусын дунд ертөнцийг шинээр тайлбарлах, үнэлэх болон шинэ үнэт зүйлс, даган дуурайх юмтай болох хэрэгцээг бий болгосон.
- Христос шашны сүлжээнүүд эхний шатандаа юуны өмнө

залуусыг өөртөө асар хүчтэй татсан байх өндөр магадлалтай. Нийгмийн дотор хүн хүнээ гэх сэтгэл улам бүр хумигдсаар буй нөхцөлд гадагш харьцахдаа үндсэндээ харилцааны чадвар сайтай, тэр чанараараа ч бусдад нөлөөлөх чадалтай хамт олны дунд орж нийгэмших бололцоог тэдгээр сүлжээнүүд олгож байв.

Гэвч өдгөө Монголын хүн амын дотор Христийн шүтлэгийг сонирхох сонирхол мэдэгдэхүйц буурсан гэхэд болохоор байна. Нэг талаар уг шашин ердөө л шинэлэг чанараа алджээ. Түүнийг сонирхох сонирхол ямартай ч Монгол улс түүхэндээ анх удаа гадагшаа нээлттэй болж эхэлсэн тийм цаг үед үүсч хөгжсөн юм. Гадаадын гэсэн юм бүхэн тэр үед шинэлэг, тиймийн учир сонирхолтой, түүнийг мэдэхсэн гэх эрмэлзэлтэй байжээ. Тэр бол урьд өмнө нь мэддэггүй байсан шинэ ертөнц рүү тэмүүлсэн үе байлаа. Нөгөө талаар Христийн шашны зарим урсгал, сүм хийдийн практик үйл ажиллагаа, тэдгээрийн дотоод амьдралд байдаг шашны царцанги үзэл номлол монголчуудыг тун удалгүй өөрсдөөсөө үлэмжхэн холдуулсан юм. Уян хатан бус, хэт улайрсан байдалтай байвал ямар ч үзэл номлол монголчуудын мөн чанарт харш байдаг.

Үүнээс гадна монголчуудын өдөр тутмын амьдрал ч бодит байдалд гүйцэгдэв. Эдийн засгийн өдөр тутмын дарамт шахалт, хүн амын өсөн нэмэгдэж буй ядуурал хүмүүсийг үндсэндээ хувь заяатайгаа эвлэрэх үзэлтэй болгожээ. Ийм нөхцөлд хүн өөрөө өөрийнхөө үнэ цэнийг дахин ухаарч эхэлсэн бөгөөд энэ нь юуны өмнө хуучин уламжлалаа баримтлагчдын байр суурийг улам бэхжүүлсэн ч хүн амын өргөн давхаргын дунд социализмын үеийн нийгмийн баталгаагаа эргэн санагалзахад хүргэсэн байна. Гэвч мөн үедээ эргэн орох хүсэл хэнд ч байхгүй байгааг саявтархан явуулсан санал асуулгын дүн харууллаа.

Шашны олон ургальч үзэл ба геополитик

Сонирхолтой нь, Христос шашныг ихээр сонирхох явдал үндсэндээ алга болчихоод байсан цаг үед шашны олон ургальч үзэл ба үндэсний аюулгүй байдлын харилцан хамаарлын тухай яригдах болжээ. Энэ маргааны цаад учрыг агуулгын талаас нь ч, цаг хугацааны талаас нь ч авч үзэн үнэлж цэгнэх учиртай юм. Өнгөн дээрээ шашны олон ургальч үзлийн тухай ярьж байгаа мэт боловч

маргааны үндсэн чиг зорилго нь Христийн шашны бүлгүүдийн үйл ажиллагаанд чиглэж байв. Гэхдээ энэ үед жишээ нь хинди шашны Ананда Марга нийгэмлэг мэтийн нилээд хачирхалтай гэмээр, мөн Монгол талын үзэж буйгаар Үндсэн хуульд ч харш үйл ажиллагаа явуулдаг Азийн шашны хэд хэдэн урсгал, бүлэглэл Монголд хөл тавиад байсан билээ.

1997 онд Засгийн газарт ойр дөт Монголын өдөр тутмын хэвлэл болон бусад сонинуудад Христос шашны зүгээс үндэсний аюулгүй байдалд учруулж буй аюулын тухай материалууд анх удаа ойр ойрхон гарах болсон юм. Арван мянган хувь Библийн судар болон Монгол Улсын Дотоод Хэргийн яамны шинжээчдийн үзэж байгаагаар "христүүд, буддистүүдийн хооронд хагарал үүсгэж, Буддийн шашныг харгис, харин Христийн шашныг бүхнийг чадагч болгон харуулж, Буддийн шашнаас дээгүүр тавьсан"¹-ыг харуулсан Христийн шашны холбогдолтой дүрс бичлэгүүдийг түр хураан авсныг Христийн шашны зарим бүлэг хурцаар эсэргүүцсэн нь Христийн номлогчид хийгээд Монгол улсын Засгийн газрын хооронд ширүүхэн маргаан үүсгэхэд хүргэв. Энэ үед Монголын хэвлэлд зүгээр нэг Христийн шашны зарим бүлгийн тодорхой үйл ажиллагаатай тэмцэх тухай биш, ер нь л Христийн шашнаас бүхэлд нь татгалзах тухай бичдэг болоод байлаа. Ингэж хавтгайруулсан нь, өөр газарт бол тэдний баримталдаг байр сууринаас Католик, эсвэл Евангель шашныхан ихэд цэрвэдэг зөвхөн тийм хэдхэн урсгал чиглэлийн (Христийн шашны) практик үйл ажиллагааны талаар л Монголд мэддэгтэй холбоотой байж болох юм. Шашны олон ургальч үзлийн аюулын тухай маргалдахад хүргэж буй шалтгаануудыг удаа дараа авч үзсэний эцэст дараах хэдэн зүйл дээр л тогтсон юм. Үүнд шашны олон ургальч үзэл:

1. Монголын ард түмний эв нэгдлийг бусниулж байна.
2. Өв уламжлалыг эргэлзээтэй байдалд оруулж байна.
3. Өрнөдийн нөлөөг бэхжүүлж байна.
4. Шашны сөргөлдөөн, бүр шашин хоорондын дайны аюулд хүргэх боломжийг нэмэгдүүлж байна.²

Ерөнхийдөө өнөөдрийг хүртэл улс төрийн ч бай, шашны ч бай

1 "Төр, шашны харилцааны талаархи албан ёсны байр суурийг тайлбарлав". Засгийн газрын мэдээ, Улаанбаатар, 1998.01.07.

2 Батхаан, Д. "Шашны шинэ урсгалуудын нөлөө, Монголын тогтвортой байдал", Стратеги судлал, Улаанбаатар, 1(1995)

олон ургальч үзэл Монголын ард түмний эв нэгдлийг ноцтой хэмжээнд хөндөж байгаагүй гэдгийг иш үндэс болгож болно. Жишээ нь, социал-демократ үзэл баримтлал хэмээх саяхан болтол монголчуудын огт мэддэггүй байсан улс төр-үзэл суртлын чиглэл тус оронд хөлөө олсон төдийгүй, Монголын Социал-Демократ Нам энэ хооронд улс төрийн эрээн мяраан амьдрал дунд бат бэх нам болон хөгжсөнийг бодож үзэхүл ийм сэтгэгдэл өөрийн эрхгүй төрнө.

Ардчилсан нийгмийн нөхцөлд шашны олон ургальч үзэл гэдэг нь шашин, шүтлэгийн олон янзын хэлбэрийг хүндэтгэн үзэх, тэдгээрийн үндсэн гол санаа, сайн муу тал хийгээд нийгэмд байгаа асуудлуудыг шийдэхэд тодорхой хувь нэмэр оруулах өөрийн гэсэн арга замын тухайд хүн амын янз бүрийн бүлгийн хоорондох ашиг сонирхлыг тэгшитгэх боломжийг хайна гэсэн үг юм. Гэвч шашны олон ургальч үзэл үүнийхээ сацуу бас “олон янзын сүсэг бишрэлийг хүлээн зөвшөөрч, тэдэнд сайнаар хандахыг”¹ шаарддаг байна.

Гэвч монгол үндэсний төр улсын үүссэн түүх, тэрчилэн газар зүйн байрлалын хувьд Орос, Хятад хоёр их гүрний дунд хавчуулагдсан, мөн Орос, Хятадын хилийн дагуух бүс нутгуудад амьдардаг монгол үндэстэн ястнууд оросжих буюу хятаджих үйл явц эрчимтэй явагддаг зэргээс болж улс орныхоо цаашдын оршин тогтноход монголчуудын санаа зовнидогийг мэдэх хэн боловч Монголд зарим хүн тус орны нийгэм тогтворгүй байгаагийн улмаас шинэ шашин орж ирэхэд наад зах нь таагүй ханддагийг ойлгож чадна байх. Христийн шашны зарим урсгалынхан монгол дагалдагсдаа хэт улайран шүтүүлэхийг ихээхэн эрмэлзэх болж, тэгснээрээ Монголын ард түмний эв нэгдлийг сахин хамгаалах Үндсэн хуулийн эрхэм дээд зарчмаас шашны зорилгоо санаатайгаар дээгүүрт тавьдаг нь улам ч ийм байдалд хүргэж байна.

Гэвч шашинтай ямар ч хамаагүй атлаа шашны асуудалд гаднаас нь хүчтэй нөлөө үзүүлж буй өөр нэг учир шалтгаан байж болох мэт. 1996 оны парламентийн сонгуульд шинэ ардчилсан намуудын эвсэл ялалт байгуулжээ.² Улс төрийн сөрөг хүчний ялалт нь Монголын нийгмийг ардчилахад чиглэсэн, юуны өмнө Герман болон АНУ-ын зүгээс логистик зөвөлгөөгөөр дэмжлэг үзүүлдэг

1 K. Lehmann, Orientierung, Verantwortung und Fundamentalkonsens in freiheitlichen Gesellschaften, KAS-Auslandsinformationen 10(1996), 6-р тал.

2 W. M. Prohl, Die Parlamentswahlen in der Mongolei am 20. Juni 1996, KAS-Auslandsinformationen 8(1996), 79-92-р талууд.

улс төрийн үйл явцын үр дүн юм. Герман, АНУ хоёр Монголд Улс төрийн, АНУ бас цэрэг-стратегийн ашиг сонирхлыг мөрдлөг болгодог хэдий ч өөр тодорхой зорилго бараг мэдэгддэггүй.

Монгол дахь эдийн засгийн амин чухал эрх ашгаа стратегийн хэмжээнд тавьдаг Япон улс Монголд хандивлагч орон, байгууллагуудын Бага хурлыг санаачилж асан 1991 оноос эхлэн тус орны хувьд хамгийн том мөнгө хандивлагч болон гарч ирсэн байна. Японы Засгийн газар 1991-1997 он хүртэл Монголд 216,9 ам. долларын буцалтгүй тусламж, 116,9 сая ам. долларын хөнгөлөлттэй зээл олгожээ. Алс Дорнодын орны стратегичид Монгол улсыг шинээр үүсч буй Зүүн Хойд Азийн эдийн засгийн бүс нутагт баттай байр эзлүүлэхээр бодож төлөвлөгөөндөө тусгасан байна. Арвин баялаг ашигт малтмалтай Монгол орон энэ дэлхийн түүхий эдийн үлдсэн зах зээл дээр бие даах нэг хэмжүүр болж чадах төдийгүй, тэр нь даяарчлалын явцад стратегийн давуу талтайгаа гарцаагүй харуулах учиртай аж. Энэ бол мэдээж Монгол улс Европын хавсралт хэвээр үлдэх үү, эсвэл харин Азийн орчиндоо эргэн ирэх үү гэдэг төвөгтэй асуудлыг шийдэх ёстой гэсэн үг юм. Тэгэхдээ, хэрвээ Монголыг Зүүн Хойд Азийн эдийн засгийн эвсэлд нэгдүүлэе гэвэл “толгойгий нь эзэмдэхийн төлөө дайн” явуулах зайлшгүй шаардлагатай болохыг зарим хүн ойлгодог байв. Тийм учраас Монголд нилээд хүчтэй байдаг хуучин уламжлалаа баримтлагч жигүүрийнхэнд ихээхэн найдлага тавьж байлаа. Энэ нь хэрэвзээ Европын байгууллагууд монголчуудад улс төрийн боловсрол олгож, Өрнө дахины Христос шашин тэдний бодол санааг тодорхойлдог болчихвол “толгойгий нь эзэмдэхийн төлөө дайн”-д ялагдана гэдгээ сайтар мэдэж байсных буй заа. Үүнтэй холбоотойгоор “Азийг азичуудад” хэмээх эдийн засгийн цөм ухагдахууны хэмжээнд багасган ойлгож болох томъёолол бага ч атугай үнэ цэнтэй байх болов уу.

Шарын шашны сэргэн мандалт

1992 оноос эхлэн Д. Чойжамц Хамба Улаанбаатар дахь Гандантэгчинлэн хийдийг толгойлж байна. МАХН-ын удирдлагаас хийдийн уг албан тушаалд тавигдаж байсан өмнөх Хамба Х. Гаадангаа бодвол Чойжамц Хамба ламынхаа хувьд огт өөр боловсрол мэдлэгтэй хүн ажээ. Тэрээр 1970-1976 оны хүртэл Улаанбаатарын Шашны Дээд Сургуульд суралцаж төгсөөд долоон

жил Гандан хийдийн унзад-ын туслахаар ажилласан байна. 1983-1986 он хүртэл Чойжамц Дармасала дахь Далай ламын Ордны Диалектикийн сургуульд шашны гүн ухаан судлав. Дараа нь тэрээр Гандангийн хамба ламын орлогч (1986-1990), хурлын лам (1990-1991) болон Да лам (1991-1992)-аар тус тус ажиллажээ. Чойжамцтан үүгээрээ дан ганц шашны суурь боловсрол, хийдийн өдөр тутмын амьдралыг зохион байгуулах баялаг туршлагатай төдийгүй, Далай ламтай зохиох хэмжээний хувийн хэлхээ холбоотой хүн юм. Тэрээр олны өмнө харьцангуй бага гарч ирдэг. Гэлээ ч гэсэн Дээдсийн хүрээлэн сонин түүнийг Ерөнхий сайд, Улсын Банкны Ерөнхийлөгч, Тагнуулын Ерөнхий Газрын дарга, Эрдэнэт концернийн Ерөнхий захирлын дараа орох тус орны хамгийн хүчтэй, нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн хэмээн нэрлэжээ.

Улаанбаатар хотод оршдог Гандантэгчинлэн хийд нь Чойжамц хамбын үед “Монголын Бурхны шашинтны төв” болон хөгжсөн юм. Энэ төвийн нэр нь Гандан хийд улс орны дотор Шарын шашныг төрийн өмнө төлөөлөхөөс өгсүүлээд уг шашинтай холбоотой аливаа хэргийг удирдах эрхийг өөртөө авах эрмэлзэлтэй байдгийг тодорхой илтгэн харуулав. Хийд нь үйл ажиллагаагаа дараах гол гурван чиглэлээр явуулдаг. Үүнд:

1. Тус хийд “хуучин уламжлалаа сэргээх”-ийн төлөө хичээн зүтгэх агаад үүнийг юуны өмнө Бурхны шашны ном, сургаалийг буцаан сэргээх гэсэн үг хэмээн ойлгож болно. Шашны Дээд сургууль энэ утгаараа хөдөөгийн хийдүүдээс ирсэн лам нарт шашны боловсрол олгох буюу боловсролыг нь ахиулах үүргийг өөртөө хүлээсэн байдаг. Ийнхүү гурван ч Чойрын дацан (шашны сургууль) Бурхны шашны гүн ухаанд сургах нарийн төвөгтэй салбарт гол анхаарлаа хандуулж байна.
2. Тус хийд нь Шарын шашны сүм, хийдүүдийг сэргээн засварлах ажилд зохицуулах үүрэгтэй оролцохыг хичээж байна.
3. Тус хийд өөрийгөө Монголын хүн амын дунд Шарын шашныг түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулах төв хэмээн үздэг.¹

Далай лам Монгол дахь Шарын шашныг буцаан сэргээх үйл

¹ “Гандантэгчинлэн хийдийн Хамба лам Д. Чойжамцтай хийсэн ярилцлага”, Билгийн мэлмий, Улаанбаатар, 1996.10.23, 8-р тал.

явцад ихээхэн анхаарал тавьжээ. Тэрээр далаас ная орчим монгол лам нарыг Дармасалад сургаж. Монголын Шарын шашинтнуудад шашны холбогдолтой ном судраар туслан, 1991, 1994, 1995 онуудад Монголд албан бус айлчлал хийснээрээ уг шашныг буцаан сэргээх үйлсэд шийдвэрлэх түлхэц өгсөн юм. Монгол Улсын Засгийн газар БНХАУ-тай тогтоосон харилцаагаа бодоод Далай ламтай албан ёсны аливаа холбоо тогтоохоос зайлсхийдэг ч гэлээ Монголын сүсэгтнүүдтэй харилцах өргөн боломжийг түүнд олгож ирэв.

Монголын Шарын шашинтнуудад мөн Японы (Наритагийн хийд, Огоншу байгууллага) болон Өмнөд Солонгосын Бурхны шашны байгууллагууд, түүнчилэн Английн Төвдийн Сангаас ихээхэн дэмжлэг үзүүлж байна.

Бакула Ринбүүчийн Монголд явуулсан үйл ажиллагаа онцгой чухал болох нь эргэлзээгүй. Урьд Далай ламын багш асан Бакула нь Бакула Гэгээний 20 дахь, Найдан хувилгааны 16 дахь хойд дүрээр тодорсон хүн юм. Тэгэхдээ түүхэн бодит Бакула нь умард зүгт Шарын шашныг дэлгэрүүлэхээр анх тийшээ зүглэснийг бэлгэдлийн агуулгатай биш гэхийн аргагүй. Энэтхэгийн Засгийн газар 1990 онд Бакулаг Монголд суух өөрийн орны Элчин сайдаар томилжээ. Ингэснээрээ Энэтхэг улсын Элчин сайд сууж буй орондоо Бурхны шашнаа тодорсон хамгийн дээд зиндааны үгсгөөд цорын ганц хувилгаан дүр болж ямартай ч олон улсын эрх зүйд жаахан төвөгтэй төдийлөн тохиолдоод байдаггүй нөхцөл байдал үүссэн билээ. Бакула маш хурдан хугацаанд Монголд Шарын шашныг буцаан сэргээх үйл явцад гол үүрэгтэй хүн болж эхэлсэн ба МАХН-ын байгуулсан Засгийн газар ямар боловч энэ байдалд нь уян хатан хандаж байв. Цаашдаа Бакула шашны гол чухал үйл явдлуудад бүгдэд нь өөийн биеэр оролцож байсан боловч нийтэд энэ талаар мэдээлэхээсээ зайлсхийдэг байлаа.

Монголын шашны амьдралд хүчтэй түлхэц өгөх үүднээс Бурхан багшийн чандрыг нааш нь нэг удаа авчруулах тухай Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийг Бакула өөрийн орны Засгийн газарт уламжилсан байна. Энэтхэг Улсын Засгийн газар энэ гуйлтыг нь ёсоор болгожээ. 1993 оны 9-р сард Улаанбаатар хотноо томоохон ёслолын арга хэмжээ болж, Монголын сүсэгтнүүд Бурхан багшийн чандарт хүндэтгэл үзүүлэх үеэр Ерөнхийлөгч П. Очирбат "Бурханы

шашин, түүгээр уламжлан Энэтхэг, Төвдийн соёл Төв Азийн Монгол хэмээх нүүдэлчин түмний соёл иргэншилд ч арилж баларшгүй гүнзгий нэвтэрч шингэсэн юм.”¹ хэмээн мэдэгдсэн юм.

Энэ хооронд хот, аймгуудад улсын бүртгэлтэй сүм, хийдийн сүлжээг тодорхой зорилготойгоор өргөтгөжээ. 1997 онд Монголд нийтдээ улсын бүртгэлтэй сүм хийд 154 байв. Тува болон Буриад (Оросын Холбооны Улс) улсуудтай хил залгаа аймгууд 43 сүм, хийдтэй байсан нь тэдгээрийн байршил нилээд өндөр нягтралтай байна гэсэн үг юм. Харин Өвөр Монголтой (БНХАУ) залгаа хилийн аймгуудад энэ тоо 21-тэй л байсан бол, Улаанбаатар-Хөх хотыг (Өвөр Монгол) холбосон төмөр замаар очиж болох аймгууд ямартай ч 34 сүм, хийдтэй байв.

Мэгжид Жанрайсэг (Авалокитешвара) шүтээнийг дахин босгож аравнайлан нь Монголын Шарын шашны амьдралд тохиосон хамгийн чухал оргил үйл явдал болсон нь дамжиггүй болов уу. Анх 1911 онд босгосноос хойш монголчуудын тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг гэж ямагт үзсээр ирсэн тэрхүү шүтээний 26,5 м өндөр баримлыг 1938 оны сталинист хэлмэгдүүллийн үеэр булаан авч явсан бөгөөд түүний байрлаж асан дуганыг энэ үеэс эхлэн улс өөр зорилгоор (ном хураах агуулах г.м.) ашиглаж байжээ. 1991 оны 2-р сарын 13-нд Ерөнхийлөгч П. Очирбат түүнийг буцаан сэргээх тухай зарлиг гаргасныг тус орны томоохон урчууд, дархцуул 1996 оны 10-р сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв. Ард олны зүгээс үүнд зориулж 153,4 сая төгрөгийн хандив цугларчээ. Японы Бурхны шашинтны Огоншу байгууллага 70 сая төгрөг хандивласан байна. Хамба лам Чойжамц, Бакула Ринбүүч нарыг байлцуулан энэхүү шүтээнийг 1996 оны 10-р сарын 25-наас 26-нд шилжих шөнө аравнайлав. 10-р сарын 27-ны өдөр, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын орлогч дарга нар оролцсон төрийн хүндэтгэлийн ёслол дээр шүтээнийг "Монголын Бурхны шашинтны төв"-д хүлээлгэн өгснөөр тэр нь Гандантэгчинлэн хийдийн мэдэлд шилжин иржээ. Монгол-Хятадын харилцааг бодолцсоны үндсэн дээр Далай лам болон Богд Жавзандамбын 9-р дүр Жамбалнамдалчойжанцан нарыг Мэгжиджанрайсэг бурхныг аравнайлах ёслолд урьж оролцуулсангүй.

Энэхүү шүтээнийг сэргээн босгосон нь үндэстний хувьд маш их

1 "Бурхан багшийн чандар Монголд" хүндэтгэлийн ёслолын нээлт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатын хэлсэн үг; Засгийн газрын мэдээ, Улаанбаатар, 1993.09.04-07.

ач холбогдолтой үйл явдал болсон юм. Ажиглагчдын үзэж буйгаар энэ нь Шарын шашныг ч, Монголын ард түмний уламжлалыг ч баримтлахаа тодорхой илэрхийлсэн хэрэг аж. Гэвч түүний жинхэнэ шашны агуулга нь энэ бүхнээс хавьгүй хальж гарах билээ. Ямартай ч Далай ламтан уг шүтээнд оролцуулах нандин эд агуурс ирүүлсний дотор Бурхан багшийн чандар бүхий долоон боодол, Балдан Адишаагийн чандар бүхий нэг боодол, Шарын шашныг шинэчлэгч Зонховын яс, чандар, мөн урьд өмнөх бүх үеийн Банчин лам нарын тэргүүний үс зэрэг зүйлс орсон байв. Жанрайсэг шүтээн нь ингэснээрээ онцгой ариун нандин шүтээний зэрэгт хүрсэн бөгөөд Тува, Буриад (Оросын Холбооны Улс), Өвөр Монголын (БНХАУ) Шарын шашинтнуудын очдог хамгийн чухал мөргөлийн газар болж ч болзошгүй юм.

Шарын шашны томоохон зүтгэлтнүүдийн үйл ажиллагаа сүүлийн үед тус орны улс төрийн амьдралд мэдэгдэхүйц эрчимжсэн юм. Энэ хооронд лам нар улс төрийн зарим томоохон арга хэмжээний өмнө ерөөл айлдах, шүүх хурал эхлэхийн өмнө цацал өргөх (сүүгээр), мөн хуралдааны завсарлагын үеэр ном унших буюу хуримын ёслолд оролцох зэрэг нь ердийн заншил болжээ.

Шарын шашны зарим зүтгэлтэн сүүлийн үед өөрсдийнх нь шашин монголчуудын нийгмийн амьдралд илүү хүчтэй нэвтэрч байгаатай холбогдуулан шашны байгууллагуудыг урьдынхаасаа илүүтэй институтжүүлэх шаардлагатай хэмээн үзэх болсон байна. Тухайлбал, Шашны Дээд Сургуулийг төгсөгчдийн нэг, одоо өөрийнхөө байгуулсан Нар Хажидын Сүмийн тэргүүнээр ажилладаг Д.Мэндбаяр лам хуучны Шанзудбын Яамны¹ жишгээр “төрөөс шашны талаар явуулах бодлогыг боловсруулж, сүм хийдүүдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй” Шашны яам байгуулахыг шаардаж байв. Чингэхдээ Мэндбаяр давын өмнө Шарын шашны зүтгэлтнүүд болон Шарын шашны байгууллагуудын төлөөлөгчид энэ яаманд ажиллах ёстой гэдэг төсөөлөлтэй байлаа. Тэрээр Шарын шашны байгууллагууд улсын дотор улс болох ёстой гэсэн маш холын бодолдоо хөтлөгдөн төрийн яамдын албан хаагчид төрийн ажилтныхаа тангаргийг тус тусын яамдыг

¹ Шанзудбын Яамыг өнөөгийн зарим монголчууд түүхийн мэдлэг дутмагаасаа болж цэвэр шашны яам байсан мэтээр үздэг. Хэрэг дээрээ 1723 онд байгуулагдсан тус яам Богд Жавзандамбын харьяаны ихээхэн нутаг дэвсгэр болон албатууд (Их Шавь)-ын хэргийг эрхэлж, харын талын засаг захиргаатай харьцуулахад тодорхой хэмжээгээр бие даасан шинжтэй байв.

даасан бурхан шүтээний өмнө өргөх учиртай гэж байжээ.¹ Түүний шаардлагуудын заримыг анх харахад хэт туйлшрамтгай, бусдаас ялгарах гэсэн этгээд хүний тавьж буй шаардлага мэт санагдавч энэ үзэл бодол нь хуучин уламжлалаа баримтлагч талынхны зарим хүнд бас чиг таалагддаг байсан аж. Хуучнаа баримтлагчид ямартай ч Алс Дорнодынхны зүгээс багагүй үндэтгэл хүлээдэг билээ

Хэдийгээр Шарын шашин энэ зуур монголчуудын нийгмийн амьдралд баттай байр суурь эзэлж чадсан ч гэлээ нийгмийн ёс суртахууныг тодорхойлогч институц болтлоо хөгжих яагаа ч үгүй байна. Чойжамц Хамба тийм учраас нийгэм дэхь сэтгэлгээг өөрчлөх ёстойг сануулдаг юм. Тэрээр хүмүүсийн сэтгэлгээ, үйл ажиллагаанд дан ганц материалаг тал нь давамгайлахаас сэрэмжлүүлэн, оюуны болоод сэтгэлийн хэрэгцээгээ бодож, хүн хүнээ гэх чанараа улам бүр гэсэээр байгаа нийгэмд өндөр ёс суртахуун, өгөөмөр сэтгэлд илүү ач холбогдол өгч байхыг монголчууддаа уриалдаг хүн. Чойжамцтан хөрш Орос улсын шашны талаар явуулж буй бодлогыг хараад монгол төрийг бодвол тус улс Оросын Үнэн алдартны шашинд хуучин эрхийг нь олгох талаар хавьгүй их зүйл хийснийг тогтоожээ. Үнэндээ ч Монголын төр 30-аад онд улс төрийн шалтгаанаар хураан авсан сүм хийдийн хөрөнгийн талаар өнөө хүртэл байр сууриа илэрхийлээгүй байна.

Дүгнэлт

Бурхны шашинтнууд хийгээд улс төрд оролцогч олон нийтийн өргөн хүрээнийхэн юуны өмнө улс төрийн агуулгаар нь өргөн утгаар тайлбарладаг “шашны олон ургальч үзэл” хэмээх ухагдахуун ба улс орны үндэсний аюулгүй байдал хоёр өөр хоорондоо нягт уялдаатай болохыг харж байна. Чингэхдээ тэд Монголын ард түмний үндэсний эв нэгдлийн баталгааг улсынхаа үндэсний аюулгүй байдлын баталгаатай адилтган үздэг юм. Тэд нийгмийн улс төрийн шинэчлэлийг гаднаас хуулбарласан, Монголын хөрсөнд суугаагүй Өрнөдийн үнэт зүйлст бус, өөрсдийн уламжлалт үнэт зүйлст тулгуурлан хийхийг шаарддаг юм. Энэ нь тийм ч буруу зүйл биш, учир нь энэхүү шинэчлэл дотоодын итгэл үнэмшлээр тэжээгдэж байгаа эсэхээс түүний үр дүн цаашдаа амь

¹ “Ганданд Перестройка хэрэгтэй юү?”. Хох толбо, Улаанбаатар, 3(115), 1997 оны 1-р сар.

бөхтэй байх уу, унах уу гэдэг нь хамаарах билээ. Өрнөдийн соёлын тухайд Бакула Ринбүүч “Тэдний соёл тэдэндээ зөв. Монголынх Монголдоо зөв... Барууны соёлын гол хэсэг нь Загалмайн шашин юм. Монгол бол Бурханы шашин гойд дэлгэрсэн улс орнуудын нэг болохоор Бурханы шашин л соёл, зан үйлийн гол цөм нь байх ёстой”¹ гэж хэлсэн юм.

¹ 9 “АЭ”-ийн уншигчдад зориулж шүлэг бичлээ. Ардын эрх, Улаанбаатар, 1995.01.13.